



ДОРНОД АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2020 оны 01 сарын 26 өдөр

Дугаар 02

Хэрлэн сум

Аймгийн Онцгой комиссын II хурал 2020 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 15:00 цагт аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын танхимд аймгийн Онцгой комиссын ажиллах журмын 1.8-д заасны дагуу өргөтгөсөн хэлбэрээр 31 гишүүд оролцохоос 21 гишүүнтэй 68% ирцтэй хуралдав.

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

1. БНХАУ-д анх бүртгэгдсэн шинэ коронавирусын халдварын нөхцөл байдлын талаарх мэдээллийг сонсох,
2. Монгол Улсын Засгийн газраас шийдвэр гарсантай холбогдуулан орон нутгаас авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг. Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаад:

- 1.1. Монгол Улсын Засгийн газрын хуралдаанаас гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх арга хэмжээний захирамжийн төслийг боловсруулж танилцуулахыг;
- 1.2. Хилийн боомтуудад ажлуулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө, зааварчилга өгөх, хяналт тавих үүрэг бүхий Эрүүл мэндийн газар, Мэргэжлийн хяналтын газар, хуулийн байгууллагаас бүрдсэн мэргэжлийн багийг томилохыг;
- 1.3. Шинэ коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх, эм, эмнэлгийн хэрэгсэл, хувийн хамгаалах хэрэгсэл, халдваргүйжүүлэлт, ариутгал хийх бүтээгдэхүүн худалдан авах, ажлын хэсгийн түлш шатахуунд шаардагдах, мөн N95 маск буюу амны хаалт зэрэг шаардлагатай материалын зардлын тооцооны саналыг аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулахыг;

Хоёр. Мэргэжлийн хяналтын газрын дарга,

Онцгой комиссын гишүүн Д.Мөнхтуяад:

- 2.1. Шинэ коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх ажлыг сумд, бүх шатны төрийн болон төрийн бус байгууллага, иргэдэд хүргэж, хамгаалах хэрэгсэл амны хаалтыг зааврын дагуу хэрэглэх зөвлөмжийг өгч ажиллахыг;

2.2.ОХУ-тай хиллэдэг Ульхан, Эрэнцав боомтод үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагч нарт мэргэжил арга зүйн заавар, зөвлөмжийг өгч ажиллах, түүнд тавих хяналтыг дээшлүүлэхийг;

Гурав. Боловсрол, соёл урлагийн газрын дарга,

Онцгой комиссын гишүүн А.Нансалмаад:

3.1.Хичээлийн сургалтын үйл ажиллагааг түр зогсоож байгаатай холбогдуулан нийтийн арга хэмжээ зохион байгуулахыг хориглохыг;

3.2.Тогтоосон хугацаанд сургуулийн насны сургалтын хөтөлбөрийн агуулгаар суралцагчдад мэдлэг олгох ажлыг цахим хэлбэрээр зохион байгуулахыг;

Дөрөв. Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн цагдаагийн хурандаа Т.Ганзоригт:

4.1.Их, дээд болон ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагааг түр зогсоож байгаатай холбогдуулан аймгийн хэмжээнд компьютер тоглоомын газар эрхлэн явуулж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хяналт, шалгалтыг зохион байгуулж, үйл ажиллагааг хориглохыг;

Тав. Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын гишүүн хурандаа Г.Нармандахад:

5.1.Аймгийн Засаг дарга, Онцгой комиссын даргаас Сүхбаатар аймгийн Засаг дарга бөгөөд Онцгой комиссын даргад "Хамтран ажиллах тухай" албан бичгийн төслийг боловсруулж танилцуулахыг;

Зургаа. Биеийн тамир спортын газрын дарга Б.Чимэддорж,


Хөгжимт драмын театрын дарга Л.Наранхүү,

Нийт байгууллагын дарга, захирагч нарт:

6.1.Нийтийг хамарсан цуглаан, хурал, спорт, урлаг, соёлын болон аялал, зугаалга, уралдаан, тэмцээн, нэгдсэн үйл ажиллагааг хориглохыг тус тус үүрэг болгов.

Онцгой комиссын хурал 16:50 цагт дуусав

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ, ОНЦГОЙ КОМИССЫН
ОРЛОГЧ ДАРГА  Ч.ГАНБАТ

АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА, ДЭД ХУРАНДАА  Д.БАТТУЛГА

